# ЕБС-ИЙН СУРАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*/11 дүгээр анги удирдсан багшаас эцэг эхэд зориулсан сургалтын модуль/*

*С.Нямгэрэл*

*/Нийслэлийн 71 дүгээр сургуулийн сургалтын менежер*

*/nyam9923@gmail.com*

**Модулийн зорилго:**

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны талаарх эцэг эхчүүдийн хандлагыг өөрчилж, тэдний мэдлэг, чадварыг нэмэгдүүлж, оролцоог сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

**Модуль хэрэгжүүлэх зөвлөмж:**

- Хүүхдийг өөрийн хүсэл сонирхол дээрээ тулгуурлан ажил мэргэжлээ зөв сонгох боломжийг хөгжүүлэх зорилгоор хөдөлмөрийн зах зээлийн сүүлийн үеийн чиг хандлага, бодит нөхцөлд байдалд үндэслэсэн ухаалаг шийдвэр гаргах, түүнийгээ үр дүнтэй төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх нь эцэг эхчүүдийн үүрэг юм.
- Эцэг эхчүүдийн АМЧБО үйл ажиллагааны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн самбар, хурал цуглаан, нэрэмжит ажлуудыг анги удирдсан багш маш их зүйлийг хийдэг тул түүнд тогтмол идэвхтэй хамрагдах хэрэгтэй.
  Ажил мэргэжлийн хөгжил, төлөвшил, ажил мэргэжлийн сонголт болон зан төлвийн талаар судалгаанд суурилсан олон онол байдаг. Энэ талын мэдээллийг www.myfuture.mn вэйб сайтаас дэлгэрэнгүй авч болно.
  Хүүхэддээ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг танин мэдэхийн тулд:

Сургуулийн түвшинд:

- Сургууль дээр зохион байгуулагддаг үйл ажиллагааг мэдэх
- Өөрийн туршлагаа солилцох
- Хаана, хэдийд, яаж ажил мэргэжлийн талаарх мэдээлэл, эх сурвалжийг олж авч болох зөвлөгөө авах, санал солилцох
- Сургуулийн түвшний хөтөлбөр боловсруулахад оролцох
- Сургуулийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Ажил мэргэжлээ сонгох, сургууль, ажлын байрыг судлах, ажиглалт хийх, туршлага судлах боломжоор хангахад дэмжлэг үзүүлнэ.
  Анги, танхимын түвшинд:
- Хичээлээс гадуурх үйл ажиллагааг дэмжих
- Ажлын байртай танилцах, туршлага судлахад туслах
- Танхимын хичээлд хүүхдийнхээ оролцоог дэмжих зорилгоор хянах
- Хүүхдийн мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд нөлөөлөх
- Ажил, мэргэжил, Их дээд сургууль, хичээл сонголтыг хийж болох хувилбаруудыг ойлгуулах

Гэрийн түвшинд:

- Хүүхдээ сайн сонсох
- Харилцан ярилцаж, зөвлөгөө өгөх
- Туршлагаа ярих, бусдын амжилтаас танилцуулах
- Ажил, мэргэжлээ улмаар Их дээд сургууль, хичээл сонгоход нь дэмжлэг үзүүлэх
- Хүйс харгалзахгүйгээр ажил, мэргэжил сонгоход дэмжлэг үзүүлэх
- Ажил, мэргэжлийн сонголтын хувилбартай өөрийн гэсэн төлөвлөгөөтэй байлгахад туслах
- Ажилд орох эсвэл ажилгүйдлийн үед ямар хувийн зохион байгуулалттай байхыг зөвлөх
- Сурагчийн гарын авлага, дасгал ажлуудыг хамтран хийж, зөвлөгөө өгөх

**Эцэг эх таны хийж болохгүй  зүйл:**

- Хүүхдийн ажил мэргэжлийн талаарх санал бодол, хүсэл сонирхлыг бүү няцаа, үгүйсгэ! Сонирхож буй ажил мэргэжлийн талаар өөрөө судалж мэдэх, өөрийнхөө нөөц боломжийн хязгаарыг танихад дэмжлэг үзүүл!
- Ажил мэргэжлийн талаарх өөрийнхөө төсөөлөл, өнгөц дүгнэлтийг бүү хэл!
- Өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо хүүхдэдээ бүү тулга!
- Өөрийнхөө биелүүлж чадаагүй хүсэл мөрөөдлөө хүүхдээрээ хийлгэх гэж бүү оролд!
- Тэдний хүсэл сонирхлыг хэтэрхий бүү хяна!
- Тэдний өмнөөс дангаараа бүү шийдвэр гарга!
- Тэдэнд хэтэрхий их нөлөөлөх гэж бүү оролд!

**АМЧБО үйл ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичиг**

- Монгол улсын Бага, дунд боловсролын тухай хуулийн 5-р зүйлийн 1.1 заалтад суурь боловсролын агуулга нь “өөрийн авьяас чадварт тулгуурлан бие даан амьдрахад шаардлагатай чадвар, дадал эзэмшүүлэхэд” чиглэсэн байхыг тодорхойлсон байна
- энэ хуулийн 6-р зүйлийн 1.3-д “бүрэн дунд боловсролын агуулга нь мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэнэ” гэж заасан
- УИХ-ын 2015 оны 12-р тогтоолоор батласан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)-ын 3.5-д Бүрэн дунд боловсролыг сонголттой, уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий, ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ” гэж заажээ
- Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн боловсролын салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний 3.2.17-д: Ерөнхий боловсролын сургуулийн сурагч ажил мэргэжлээ сонгох, суралцах сургуулиа сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар ажил мэргэжлийн зөвлөгөө үзүүлдэг үйлчилгээг бий болгоно” гэж заасан

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан баталсан төлөвлөгөөнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгохтой холбоотой дараах 3 арга хэмжээний зорилтыг (2017-2018) тусгасан байна.

Үүнд: - ЕБС-ийн сурагчдад ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох талаар шийдвэр гаргаж, холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах

Ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээг зохион байгуулах ажлын агуулга, хөтөлбөрийг боловсруулж, мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах (240 сая төгрөг, гадаад эх үүсвэрээс) Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх онлайн үйлчилгээг бий болгох талаар холбогдох мэргэжлийн болон ТББ-тай хамтран ажиллах (120 сая төгрөг, гадаад эх үүсвэрээс)

***Ажил мэргэжлийн чиг баримжаа гэж юу вэ?***

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн ажил мэргэжлийн чиг баримжаа нь **суралцагчид болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад** ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох, 12 дугаар анги төгссөний дараа суралцах мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон их, дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой **ухаалаг, бодитой шийдвэр** гаргахад дэмжлэг үзүүлдэг сургуулийн болон сургуулиас гадуурх үйл ажиллагаа юм[1].

**Эзэмших мэдлэг, чадвар:**

Таны 11 дүгээр ангийн хүүхдийн АМЧБО үйл ажиллагаагаар эзэмшсэн байх ёстой чадамжууд:

| Анги | Чадамж |
|---|---|
| 11дүгээр анги | 1. 10 дугаар ангидаа хийсэн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах |
| | 2. Дээд боловсрол, МБС, хөдөлмөрийн зах зээлийн сонголтоо хийх |
| | 3. Ажил мэргэжлийн сонголтын боломжоо анхааралтай үнэлж дүгнэх |
| | 4. Дээд боловсрол, МБС-ын талаар түр хугацааны шийдвэр гаргах |

11 дүгээр ангийн сурагчдын ажил мэргэжлийн чиг баримжаатай болохын тулд багшийн боловсруулсан хөгжүүлэх дасгалуудыг эцэг эхчүүдтэй хамтран гүйцэтгүүлэх байдлаар гэрт нь ажиллуулж болно. Дасгал бүр өөрийн зорилготой болохыг эцэг эхчүүдэд ойлгуулах шаардлагатай. Тухайлбал:

| **анги** | **мэдлэг** | **чадвар** |
|---|---|---|
| | **Тодорхой ажил хөдөлмөр эрхлэхэд хэдэн төрлийн үүрэг гүйцэтгэх шаардлагатай** | **Ажил олгогчид хүмүүсийг ажилд авахдаа ямар чанар, чадварт** |

<table>
<tr><td rowspan="6">11</td><td>байдаг, ажил хөдөлмөрийн бодит нөхцөл байдал ямар байдаг талаар мэдэх</td><td>суурьладаг талаар мэдээлэл боловсруулах</td></tr>
<tr><td colspan="2">Дасгал 1.<br>Өдөр тутмын сонин сэтгүүл (ӨНӨӨДӨР, ӨДРИЙН СОНИН гэх мэт) эсвэл вэбсайт (http://biznetwork.mn  http://hudulmur-halamj.gov.mn/job/list гэх мэт)-аас ямар нэг ажлын зар сонгуулах. Ажлын зарыг уншуулж, хүснэгт бөглүүлнэ. Янз бүрийн мэдээлэл, мэдлэг, ойлголт болон таамаглалаа ашиглан дэлгэрэнгүй бөглөх тал дээр багш зөвлөх.</td></tr>
<tr><td>Ажил мэргэжил бүр өөр өөрийн онцлог чадвар шаардсан байдаг болон өөрийн сайн эзэмшсэн болон хөгжүүлэх шаардлагатай чадваруудыг мэдэх</td><td>Эзэмшсэн чадваруудаа мэдэх, зарим дутуу байгаа чадваруудаа нөхөх болон хөгжүүлэх</td></tr>
<tr><td colspan="2">Дасгал 2.<br>Хувь хүний, практикийн болон хүмүүс хоорондын багц чадваруудаас сурагчын хэдийн эзэмшсэн байгаа чадвар болон хөгжүүлэх шаардлагатай чадварыг тэмдэглүүлж, хамгийн сайн 5 чадварыг эрэмблүүлэх.<br><br>ХУВЬ ХҮНИЙ ЧАДВАР</td></tr>
</table>

| ***Чадвар: Би…*** | ***Э*** | ***ХШ*** | ***Чадвар: Би…*** | ***Э*** | ***ХШ*** |
|---|---|---|---|---|---|
| *Үнэнч шударга* | | | *Итгэл даасан* | | |
| *Бусдаас хараат* | | | *Алиа хошин* | | |
| *Сурах хүсэл эрмэлзэлтэй* | | | *Нөхөрсөг, нийтэч* | | |
| *Өөртөө итгэлтэй* | | | *Эмх цэгцтэй* | | |
| *Зорилготой* | | | *Алдаагаа хүлээн зөвшөөрдөг* | | |
| *Бүтээлч* | | | *Шүүмжлэлийг хүлээн авдаг* | | |
| *Урам зориг дүүрэн, идэвхтэй* | | | *Өөрийгөө чөлөөтэй илэрхийлдэг* | | |
| *Асуудал шийдэгч* | | | *Багийн тоглогч* | | |
| *Нягт нямбай, цаг баримталдаг* | | | *Бие даасан* | | |
| *Практикийн* | | | *Эерэг* | | |
| *Эелдэг* | | | *Тайван* | | |
| *Дасан зохицохдоо сайн* | | | *Аналитик* | | |
| *Амбицтай, өсөж хөгжих дуртай* | | | *Нууръмгий* | | |

*Дээрх чадвараас хамгийн сайн "ХУВЬ ХҮНИЙ ЧАДВАР"-аа сонгож, эрэмбэлнэ үү! (1 хамгийн сайн гэх мэт доошоо эрэмбэлнэ):*

| | |
|---|---|
| *1.* | *4.* |
| *2.* | *5.* |
| *3.* | |

**ТЕХНИК БОЛОН ПРАКТИК ЧАДВАР**

| Чадвар: Би ...-д хамгийн сайн | Э | ХШ | Чадвар: Би ...-д хамгийн сайн | Э | ХШ |
|---|---|---|---|---|---|
| Илтгэл, тайлан, захиа бичих | | | Гараар эсвэл гарын доорх багаж хэрэгсэл ашиглан ажиллах | | |
| Шинэ санаа гаргах, төсөөлөх | | | Судалгаа хийх | | |
| Зурах | | | Материалын тухай таньж мэдэх | | |
| Дизайн гаргах, зохиох | | | Мөнгө төгрөгийг зохицуулах | | |
| Гадаад хэлээр харилцах | | | Ямар нэг зүйл хийх | | |
| Утсаар ярих | | | Тоотой ажиллах | | |
| Интернетээр судалгаа хийх | | | Хоол хийх | | |
| Машин барих | | | Хэрэглээний програм дээр ажиллах | | |
| Бүртгэл хөтлөх | | | Механик асуудлыг ойлгох | | |
| Мал маллах | | | Мал амьтныг асрах | | |
| Ургамал тарих | | | Цэцэрлэгжүүлэх | | |

*Дээрх чадвараас хамгийн сайн "ТЕХНИК, ПРАКТИКИЙН ЧАДВАР"-аа сонгож, эрэмбэлнэ үү! (1 хамгийн сайн гэх мэт доошоо эрэмбэлнэ):*

| | |
|---|---|
| 1. | 4. |
| 2. | 5. |
| 3. | |

**ХҮМҮҮС ХООРОНДЫН БОЛОН БАГААР АЖИЛЛАХ ЧАДВАР**

| Чадвар: Би ... чадна | Э | ХШ | Чадвар: Би ... чадна | Э | ХШ |
|---|---|---|---|---|---|
| Бусадтай сайн ажиллах | | | Танихгүй хүнтэй уулзах, мэндлэх | | |
| Сайн харилцах | | | Бусдын санал бодлыг асууж, таньж мэдэх | | |
| Бусдыг удирдах, манлайлах | | | Бусад хүмүүс сонсож байгаа эсэхэд хяналт тавих, анхаарал хандуулах | | |
| Хурал уулзалт удирдах | | | Бүлгийн өмнө ярих | | |
| Бусдад удирдуулах | | | Бусдын санааг дагах | | |
| Ямар нэг зөрчлийг шийдвэрлэх | | | Бусдыг хөхүүлэн дэмжих | | |
| Бусдыг сонсох | | | Удирдах эсвэл эрх мэдэл бүхий албан тушаалын хүнтэй сайн хамтарч ажиллах | | |

*Дээрх чадвараас хамгийн сайн "ХҮМҮҮС ХООРОНДЫН БОЛОН БАГААР АЖИЛЛАХ ЧАДВАР"-аа снгож, эрэмбэлнэ үү! (1 хамгийн сайн гэх мэт доошоо эрэмбэлнэ):*

| | |
|---|---|
| 1. | 4. |
| 2. | 5. |
| 3. | |

| | |
|---|---|
| ***Сонгосон*** **мэргэжлийн үндсэн ажил үүрэг юу болох, энэ ажил мэргэжилтэй хамгийн сайн уялдах хичээлүүд, ямар их, дээд сургууль эсвэл МБС-д суралцах шаардлагатай тухай, сургалтын хугацаа, төлбөр болон бусад зардал, яагаад энэ ажил мэргэжлийг** | **Сонгосон ажил мэргэжилтэй болохын тулд одооноос юу хийх ёстой талаар интернет эх сурвалж, ном гарын авлага ашиглан судалгаа хийх** |

| | | |
|---|---|---|
| | **сонирхож байгаа шалтгааныг нарийвчлан мэдэх** | |

Дасгал 3.

Сонгосон 5 ажил мэргэжлийн дагуу нарийвчлан судалгаа хийх. Дасгалуудыг ажиллахдаа интернет эх сурвалж, ном гарын авлага ашиглах эсвэл ангийнхаа хүүхдүүдтэй зөвлөлдөж болно.

| |
|---|
| *1. Албан тушаалын нэр* |
| *2. Үндсэн ажил үүргийг товч тайлбарлан бичнэ үү* |
| *3. Энэ ажил мэргэжлийг эзэмшихэд ахлах ангид ямар хичээл сонгон судлах хэрэгтэй вэ?* |
| *4. Энэ ажил мэргэжилтэй болохын тулд ямар их, дээд сургууль эсвэл МБС-ын байгууллагад сурах хэрэгтэй вэ? 2-3 их, дээд сургууль эсвэл МБС-ын байгууллагыг бичнэ үү!*<br>*1. ...*<br>*2. ...*<br>*3. ...* |
| *5. Сургалтын хугацаа ямар байх вэ?* |
| *6. Сургалтын зардал ямар байх вэ?* |
| *7. Энэ ажил мэргэжил яагаад таны чадвар, оюун ухааны хэв шинжтэй тохирно гэж бодож байна вэ?* |
| *8. Энэ ажил мэргэжилтэй болоход дараах 3 алхам их чухал юм. Энд тухайн ажил мэргэжилтэй холбоотой ахлах ангид ямар хичээл сонгох, элсэлтийн шалгалтаа ямар хичээлээр өгөх, хэдэн оноо авах, өөрийгөө хэрхэн бэлтгэх гэх мэт үйл ажиллагааны алхмуудын бичиж болно.*<br>*i)*<br>*ii)*<br>*iii)* |

| | | |
|---|---|---|
| | **Ажил мэргэжлийн төлөвлөгөө хийхэд ашиглах эх сурвалжийн талаар судалгаа хийх, түүнийг ашиглах, энэ төлөвлөгөө хийх мэдээллийг илүү системтэйгээр боловсруулах бүрэн мэдээлэл авах талаар мэдэх** | **Ажил мэргэжлийн төлөвлөгөө хийхтэй холбоотой мэдээллийг үнэлэх чадварт суралцах** |
| | Дасгал 4. | |

<table>
<tr><td></td><td>Ажил мэргэжлийн төлөвлөгөө хийхэд ашиглах интернетийн эх сурвалжийн талаар судалгаа хийх.<br><br>
1. Төрийн өмчийн МБС-ын байгууллага, сургуулиуд, түүнд элсэн суралцахтай холбоотой мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!<br>
i. ...<br>
ii. .....<br>
iii. ....<br>
iv. ... гэх мэт<br><br>
2. Хувийн МБС-ын байгууллага, сургуулиуд, түүнд элсэн суралцахтай холбоотой мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!<br>
i. ...<br>
ii. .....<br>
iii. ....<br>
iv. ... гэх мэт<br><br>
3. Төрийн өмчийн их дээд сургуулиуд, түүнд элсэн суралцахтай холбоотой мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!<br>
i. ...<br>
ii. .....<br>
iii. ....<br>
iv. ... гэх мэт<br><br>
4. Хувийн их дээд сургуулиуд, түүнд элсэн суралцахтай холбоотой мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!<br>
i. ...<br>
ii. .....<br>
iii. ....<br>
iv. ... гэх мэт<br><br>
5. Их, дээд сургууль, МБС-ын байгууллагад суралцах тэтгэлэг болон санхүүгийн дэмжлэгийн талаарх мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!<br>
i. ...<br>
ii. .....<br>
iii. ....<br>
iv. ... гэх мэт<br><br>
6. Тодорхой ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн ажил үүрэг болон тэдгээрт тавигдах шаардлагын талаарх мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!<br>
i. ...<br>
ii. .....<br>
iii. ....<br>
iv. ... гэх мэт</td></tr>
</table>

**Арга зүй:**

Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ажиллахдаа:

| Хүүхдийн эзэмших чадвар | Эцэг эх юу хийх хэрэгтэй вэ? |
|---|---|
| хичээл болон суралцагчдын сонирхож буй ажил мэргэжил, боловсрол, сургалтын боломжуудын хоорондын уялдааг таньж мэдэхэд дэмжлэг үзүүлэх | ○ Энэ чадварыг эзэмшүүлэхийн тулд багшийн бэлтгэсэн дасгалыг ажиллуулахдаа хүүхэдтэйгээ хамтран ярилцаж, аль болох их мэдээллээр хангахад туслах, анхаарах |
| ажил мэргэжлийн болон сургалтын олон янзын боломжийн талаар эргэцүүлэхэд чиглүүлэх | ○ мэдээллийн эх сурвалж, цахим мэдээллийг боловсруулан ашиглах |

| | |
|---|---|
| | ○ сургууль, ажлын байранд дагуулж очиж танилцах |
| хүйсийн талаарх итгэл үнэмшил ажил мэргэжлийн сонголтод хэрхэн нөлөөлөх, ажил хөдөлмөр бидний амьдралын үндсэн үүрэгт нөлөөлдгийг таньж мэдэхэд дэмжлэг үзүүлэх | ○ хүүхдийн сонирхол дээр тулгуурлан мөрөөдөл, хүсэл тэмүүллийг нь дэмжих<br>○ буруу хэвшмэл үзэл бодлыг тулгахгүй байхад анхаарах |

**Ажил мэргэжлийн чиг баримжааны мэдлэг, чадвар эзэмшүүлэх, холбогдох үйл ажиллагаанд хэрхэн хамрагдах боломжууд:**

| МЭДЛЭГ, ЧАДВАР | СУРГУУЛИЙН ОРЧИНД | СУРГУУЛИАС ГАДУУР |
|---|---|---|
| **Төрийн болон хувийн их дээд сургууль, МБС-ын байгууллага, сургууль, өдрийн, эчнээ, оройн, зайн болон ЦОС сургалтын төрлийн талаарх мэдээлэл. Энэ мэдээлэл нь хөтөлбөрийн зорилго, зорилт, тухайн хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэргэжил, сургалтын хугацаа, зардал болон хөтөлбөрөө дүүргээд ажил хөдөлмөр эрхлэх боломжийн талаар агуулгатай** | - Ажил мэргэжилтэй холбоотой сурталчилгаа, ном, гарын авлага ашиглах<br>- МБС, их дээд сургууль, зайны болон цахим сургалтын тухай вэбсайтууд (www.mergejil.mn, www.num.edu.mn, www.msue.edu.mn гэх мэт)-тай танилцах зөвлөгөө авах<br>- Төгсөгч, их дээд сургуулийн оюутан, эцэг эх, сургалтын байгууллагын төлөөлөлтэй хамтран<br>- илтгэл тавих, ярилцлага хийх (МБС, их дээд сургууль, зайны болон цахим сургалтын)<br>- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн судалгааны институтын “Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага”-ын судалгаатай танилцах | ✓ Вэбсайтаас шаардлагатай мэдээлэл цуглуулах<br>✓ Сургалтын байгууллагуудын элсэлтийн талаарх мэдээлэл, гарын авлага, брошур ашиглах<br>✓ Сургалтын байгууллагуудад зочлох<br>✓ Боловсролын яармаг, үзэсгэлэн үзэх<br>✓ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах |
| **Ажил мэргэжлийн төлөвлөлт хийхтэй холбоотой мэдээллийг хаанаас яаж цуглуулах болон мэдээллийн эх сурвалжийг үнэлэх** | - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран зохион байгуулахад оролцох<br>- Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөхөд хамрагдах | ✓ Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөх<br>✓ Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах |
| **Ажил мэргэжил, сургалтын талаарх хөндлөнгийн мэдээлэл** | 10 дугаар ангид судалж буй “Суралцагчийн гарын авлага” ашиглаж сурах | ✓ Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөх, |

| | | |
|---|---|---|
| **болон өөрийн чадвар, сонирхлын талаарх мэдээллийг ашиглан төлөвлөлтийг хэд хэдэн хувилбартай хийх** | | ✓ Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах |
| **Ажилгүйдэлд бэлтгэлтэй байх** | - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаанд оролцох<br>- Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөхөд хамрагдах | ✓ Гэр бүл найз нөхдийн туршлага, ажиглалт<br>✓ Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтний зөвлөгөө авах |
| **Ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэл болох ажил хайх чадвар. Энд:**<br>**-Өргөдөл бичих**<br>**-Товч намтар, CV боловсруулах**<br>**-Ажлын ярилцлага бэлтгэх**<br>**-Ажил хайхад өөрийн мэдэх сүлжээг ашиглах**<br>**-Ажилд зуучлах байгууллагуудтай танилцах**<br>**-Орон нутгийн хөдөлмөрийн хэлтсийн мэдээллийг ашиглах** | - Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилтан уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөхөд оролцох<br>- Төгсөгч, эцэг эх болон ажил олгогчид уулзалт, ярилцлага хийхэд дэмжлэг үзүүлэх<br>- Ротари клуб, Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, ТББ-тай хамтран уулзалт, ярилцлага зохион байгуулах | Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтэст зочлох |
| **Ажлын байранд шаардлагатай мэдлэг, чадвар:**<br>**-Хөдөлмөрийн хууль, гэрээний талаар мэдэх (хүйсийн асуудлыг мөн авч үзэх)**<br>**-Ажлын байрны зан үйл болон бусад шаардлага**<br>**-Хөдөлмөрийн зах зээлд хэрхэн хөдөлгөөнтэй, идэвхтэй байх** | - Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилтан уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх ажлыг хамтран зохион байгуулах<br>- Орон нутаг дахь Худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн салбар байгууллагууд танилцуулга, уулзалт, ярилцлага хийхэд дэмжлэг үзүүлэх | - Ажлын байранд зочлох |
| **Хувиараа хөдөлмөр болон аж ахуй эрхлэх** | - Ротари клуб эсвэл Худалдаа аж үйлдвэрийн тэнхимтэй хамтран хувиараа аж ахуй, хөдөлмөр эрхлэгчийг урьж уулзалт, ярилцлага хийх | - Сайн дурын байгууллагатай хамтран ажиллах |

| | | |
|---|---|---|
| | - Суралцагчдын дунд “мини-аж ахуй эсвэл компани” үүсгэх, удирдахад дэмжлэг үзүүлэх клубууд ажиллуулах | |

**Мэдлэг, чадвар үнэлэх:**

- Хүүхдийнхээ мэдлэг, чадвар эзэмшиж чадаж буйг дараах байдлаар ажиглан, дүн шинжилгээ хийж болно. Үүнд:
    - Ирээдүйгээ хэрхэн төлөвлөж буй байдал
    - Сурах арга барилд өөрчлөлт гарч буй байдал /ялангуяа сонгосон хичээлийн хувьд/
    - Сонирхол нь өөрчлөгдөж байгаа эсэх
    - Их дээд сургуульд сурах боломжуудыг мэдэж буй байдал
    - Ажил хөдөлмөр эрхлэх үед өөрийгөө хэрхэн бэлдэх, мэдээллийг хаанаас авах
- Хүүхэд өөрөө өөрийгөө үнэлэх дасгалуудыг ажиллуулах
    - Багшийн тусламжийг авч болно.
- Асуулт асууж харилцан ярилцах /ямар сэдвээр, яаж асуухаа төлөвлөх, багшийн тусламжийг авч болно./ Жишээ нь:
    - Ямар ажил мэргэжил сонгох хэрэгтэй талаар тодорхой бодол, санаа байна уу?
    - Ямар хичээлийг сонгосон, тэр нь чиний сонгосон ажил мэргэжилтэй яаж холбогдож байна?
    - Сонгосон сургуульд ямар хэлбэрээр сурч болох, өөр ажил хөдөлмөр эрхэлж болох, ямар хувилбарууд байж болох талаар асуух
      Үүнээс өөр асуултууд ч байж болно.
- Сорил тест ажиллуулах
    - Багшийн тусламж авах эсвэл мэргэжлийн байгууллагад хамрагдаж болно.

**Ашиглах ном зүй:**

АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018
- Сургуулийн удирдлагын гарын авлага, АХБ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ УЛААНБААТАР 2016
- Багшийн гарын авлага, АХБ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ УЛААНБААТАР 2016

**Цахим эх сурвалж:**

- **www.myfuture.mn**
- **www.mergejil.mn**
- **http //hudulmur-halamj.gov.mn/occ**
- **http //jobclass.ubstat.mn/occ**
- www.onisep.fr
- www.myworldofwork.co.uk
- www.careers.govt.nz
- https://myfuture.edu.au

  https://www.onetonline.org TUYA
- https://hutulbur.num.edu.mn/
- http://ubbirj.ub.gov.mn/

"Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй" тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох "Чанартай боловсрол"-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.
Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.
Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ